2107	Томилолт, зочны зардал	9,426,400.00	9,424,400.00	9,424,400.00	0.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	9,426,400.00	9,424,400.00	9,424,400.00	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,166,700.00	36,558,322.00	36,558,322.00	296,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,745,000.00	18,717,748.00	18,717,748.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	0.00	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	793,000.00	790,700.00	790,700.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	121,100.00	121,100.00	0.00

Хужирт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,543,300.00	14,212,160.00	14,212,160.00	296,000.00
210807	Газрын төлбөр	2,353,400.00	2,116,614.00	2,116,614.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00	0.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	600,000.00	600,000.00	600,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,827,700.00	221,139,675.00	133,217,565.00	94,583,710.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	220,347,700.00	199,659,675.00	199,659,675.00	5,301,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,480,000.00	21,480,000.00	21,480,000.00	1,360,000.00
211	ХҮҮ	0.00	0.00	0.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,266,100.00	26,266,100.00	26,266,100.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,266,100.00	26,266,100.00	26,266,100.00	0.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0.00	0.00	0.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,866,100.00	18,866,100.00	18,866,100.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,400,000.00	7,400,000.00	7,400,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	587,931,000.00	461,236,009.00	461,236,009.00	50,000,000.00
220001	Барилга байгууламж	0.00	0.00	0.00	0.00
223001	Бусад хөрөнгө	587,931,000.00	461,236,009.00	461,236,009.00	50,000,000.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө	0.00	0.00	0.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	195,763,100.00	195,700,000.00	0.00	195,700,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	195,763,100.00	195,700,000.00	195,700,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,375,024,800.00	2,216,259,595.28	1,453,868,157.45	1,027,938,007.83
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	1,143,011,380.45	-932,011,180.45
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	1,825,268,605.28	1,614,268,405.28
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,458,635,700.00	2,021,818,152.28	196,549,547.00	1,939,575,835.28
320001	Орон нутгийн төсвөөс	1,262,086,200.00	1,825,268,605.28	0.00	1,760,268,605.28
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	196,549,500.00	196,549,547.00	196,549,547.00	179,307,230.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	916,389,100.00	194,441,443.00	114,307,230.00	20,373,353.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	159,230,000.00	185,660,486.00	185,660,486.00	-59,760,860.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,577,700.00	8,780,957.00	8,780,957.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	727,581,400.00	0.00	183,596,702.00	-183,596,702.00

Хужирт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	184,460,702.00	0.00	183,596,702.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	176,229,573.00	0.00	121,773,203.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	154.00	76.00	0.00	76.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	0.00	2.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00	0.00	2.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	76.00	37.00	0.00	37.00
620001	Удирдах ажилтан	10.00	10.00	0.00	10.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	0.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	0.00	1.00
620004	Гэрээт ажилтан	52.00	13.00	0.00	13.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	76.00	37.00	0.00	37.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12.00	12.00	0.00	12.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	0.00	0.00	0.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30.00	3.00	0.00	3.00
650010	Гэрээт ажилтан	25.00	13.00	0.00	13.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00	0.00	9.00
650012	Шүүгч, прокурор	0.00	0.00	0.00	0.00
650013	УТҮГ	0.00	0.00	0.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	97,535,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,535,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,535,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,745,000.00
210604	Урсгал засвар	5,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,713,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,713,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,077,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,077,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,000,000.00
220001	Барилга байгууламж	0.00

223001	Бусад хөрөнгө	50,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	97,535,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,535,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,437,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,098,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сумын санхүүгийн алба нь Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил гүйлгээг хянах, ажил гүйлгээг батлах чиг үүргийг гүйцэтгэдэг.

Санхүүгийн албанд дарга-1, мэргэжилтэн-1, нягтлан бодогч -3 нийт 5 орон тоотой ажиллаж байна. Тус суманд төсөвт байгууллага-9, ОНӨААТҮГазар -1, орон нутгийн сан-3 үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хужирт сумын Төрийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

Хужирт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,565.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	831.9	909.1	77.2
Авлага	472.2	579.9	107.7
Бараа материал	579.4	101.9	-477.4
Үндсэн хөрөнгө	8,755.0	2,482.5	-6,272.5
Нийт хөрөнгө	10,638.6	4,073.6	-6,565.0
Өр төлбөр	134.2	0.008	-134.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,504.3	4,073.5	-6,430.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,638.6	4,073.6	-6,565.0

Тайлант онд сумын ОНХСанд 158.8 сая төгрөг, СХСанд 81.0 сая төгрөгийн авлага нэмэгдэж, ЭХСангийн авлага 2.1 сая төгрөг, ЭМТөвийн авлага 129.8 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын үлдэгдэл 477.4 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 6,272.5 сая төгрөгөөр буурсан нь мөн боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр 134.2 сая төгрөгөөр буурсан нь ЭМТөвийн 129.8 сая төгрөгийн өмнөх оны өглөг хасагдсантай холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 909.1 сая төгрөг болж, өмнөх оноос 77.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0	0	
Банканд байгаа бэлэн мөнгө	831.9	909.1	77.2

Хужирт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төгрөг			
Төрийн сангийн харилцах	813.7	907.0	93.3
Арилжааны банк дахь харилцах	18.3	2.2	-16.1
Дүн	831.9	909.1	77.2

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна. СХСан, ЭХСан ОНХОрлого, ОНХСан зэрэг байгууллагууд мөнгөн хөрөнгийг үлдэгдэлтэй гарчээ.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 579.9 сая төгрөг болж, өмнөх оноос 107.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.13	0.16	0.03
Зээлийн хүүгийн авлага	4.1	16.6	12.5
Бусад авлага	130.0	0	-130.0
Байгууллагаас авах авлага	1.8	0	-1.8
Хувь хүмүүсээс авах авлага	336.2	563.1	226.9
Дүн	472.2	579.9	107.7

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагын 97.1 хувийг хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь ЭХСангаас олгосон өвс тэжээлийн авлага 39.7 сая төгрөг, СХСангаас олгосон зээлийн авлага 354.9 сая төгрөг, ОНХСангийн хувь хүмүүсээс авах авлага 168.5 сая төгрөг байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 101.9 сая төгрөг болж, өмнөх оноос 477.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	390.8	5.4	-385.4
Тусгай зориулалттай материал	369.7	5.4	-385.4
Эм боох материал	21.1	0	-21.1
Дуусаагүй үйлдвэрлэл			
Бэлэн бүтээгдэхүүн	8.4		-8.4
Хангамжийн материал	138.8	57.2	-81.6
Бичиг хэргийн материал	11.1	5.5	-5.6
Аж ахуйн материал	65.8	45.4	-20.4
Сэлбэг хэрэгсэл			
Түлш, шатах тослох материал	0.4		-0.4
Барилгын засварын материал	8.3		-8.3
Хүнсний материал	43.0		-43.0
Бусад хангамжийн материал	10.2	6.3	-3.9
Мал амьтад	41.3	39.3	-2
Дүн	579.3	101.9	-477.4

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 477.4 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,482.5 сая төгрөг болж, өмнөх оноос 6,272.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	8,451.9	2,320.8	-6,131.1
Барилга, байгууламж, орон сууц	6,411.2	598.4	
Авто-тээврийн хэрэгсэл	283.9	250.2	
Машин тоног төхөөрөмж(компьютер)	454.7	85.5	
Тавилга, аж ахуйн эд хогшил	123.5	21.0	
Зам, гүүрийн байгууламж	492.8	452.0	
Бусад үндсэн хөрөнгө	470.9	539.7	
Дуусаагүй барилга, байгууламж	181.0	374.0	
Ном	33.9	0	
Биет бус хөрөнгө	303.1	161.7	-141.5
Программ хангамж	2.7	6.3	
Бусад биет бус хөрөнгө	300.4	155.4	
Дүн	8,755.0	2,482.5	-6,272.5

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 6,272.5 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой.

Сумын ЗДТГ, ИТХ зэрэг байгууллагууд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 249.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэлд авсан, 43.1 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө бэлтгэж бүртгэлд тусгажээ.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 0.008 сая төгрөг болж, өмнөх оноос 134.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	35.9	0	-35.8
Байгууллагад төлөх өглөг	89.9	0	-89.9
Хувь хүмүүст төлөх өглөг	8.4	0.008	-8.39
Дүн	134.2	0.008	-134.1

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЭМТөвийн өмнөх оны өглөг 129.7 сая төгрөг хасагдсан байна. Мөн СХС-ийн өмнөх оны өглөг 3.2 сая төгрөг хасагдаж, 0.008 сая төгрөгийн өртэй гарчээ.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,073.5 сая төгрөг болж, өмнөх оноос 6,430.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,755.0	1,372.5	-2,382.5

Хужирт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4.6		-4.6
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
Хуримтлагдсан үр дүн			
Өмнөх үеийн үр дүн	3,258.4	8,780.8	5,522.4
Тайлант үеийн үр дүн	21.9	-6,421.5	-6,443.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,464.4	341.7	-3,122.7
Дүн	10,504.3	4,073.5	-6,430.8

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмчийн дүн буурсан нь улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийн эхний үлдэгдлийг зардалд хааснаас тайлант оны үр дүн буурсантай холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2021 оны 8/6/2 тоот тогтоолоор 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,535.8 сая төгрөгөөр баталжээ.

Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай 2022 оны 8/9/2 тогтоолоор төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,375.0 сая төгрөг болгон бууруулж баталсан байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 207.9 сая төгрөгөөр хасагдсантай холбоотой.

Сумын төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 789.6 сая төгрөгөөр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 806.3 сая төгрөг буюу 99.4 хувиар давж биелжээ.

Хүснэгт-9

сая төгрөгөөр

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Хүн амын орлогын албан татвар	31,908,200.00	36,542,576.15	4,634,376.15	114.52%
2	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	194,071,400.00	153,970,052.88	(40,101,347.12)	79.34%
3	Галт зэвсгийн албан татвар	2,070,000.00	2,250,000.00	180,000.00	108.70%
4	Улсын тэмдэгтийн хураамж	2,700,000.00	2,826,172.00	126,172.00	104.67%
5	Газрын төлбөр	52,136,700.00	31,997,579.00	(20,139,121.00)	61.37%
6	Ус ашигласны төлбөр	560,000.00	312,000.00	(248,000.00)	55.71%
7	Ойн нөөц ашигласны төлбөр	15,000,000.00	31,202,070.00	16,202,070.00	208.01%
8	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	23,000,000.00	48,144,552.84	25,144,552.84	209.32%
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	6,000,000.00	-	(6,000,000.00)	0.00%
10	Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	70,223,000.00	130,751,806.52	60,528,806.52	186.20%
11	ХХОАТ	391,047,500.00	624,905,357.68	233,857,857.68	159.80%
12	Хөрөнгө борлуулсны орлого	7,167,000.00	8,460,000.00	1,293,000.00	118.04%
13	Ан амьтан нөөц ашигласны төлбөр		376,157,124.00	376,157,124.00	

14	Малд ногдуулах албан татвар		160,345,019.00	160,345,019.00	
15	Татварын буцаан олголт	(29,779,500.00)	(40,514,645.10)		
	Татварын орлого	766,104,300.00	1,567,349,664.97	811,980,510.07	204.59%
1	Татварын бус /Хүү, торгуулийн орлого	34,259,000.00	28,562,000.00	(5,697,000.00)	83.37%
	Нийт дүн	800,363,300.00	1,595,911,664.97	806,283,510.07	199.40%

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн ч үйл ажиллагааны орлого, газрын төлбөр, ус ашигласны төлбөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого зэрэг татварууд 55.71-79.34 хувиар тасарсан байна. Мөн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого огт ороогүй тасарсан байгаа нь тайлант оны дараа орлого нь орж ирсэнтэй холбоотой байна.

ХХОАТ, хог хаягдлын үйлчилгээний хураамж, ойн нөөц ашигласны төлбөр мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 59.8-109 хувь давсан байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, малд ногдуулах албан татварын орлого төлөвлөгөөгүй орлого орсон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 97.5 сая төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний бусад зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардал зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хужирт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын захирал, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Хужирт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 1/27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 1,912.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 19.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор суманд олгох санхүүгийн дэмжлэг буурч, төсөвтөө хасах тодотгол хийсэн ба тэр хэмжээгээр холбогдох зардлууд хэмнэгдсэн байна.

Энэ хуулийн хүрээнд сумын ИТХ-д тээвэр шатахууны зардлыг 0.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хужирт сумын ТТЗ нь 2022 онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар ТТЗ-тай холбоотой зөрчил илрээгүй.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 зөрчил¹ илэрч, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага гараагүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шийдвэр гаргалт, үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумдын төсөвт байгууллагуудын дарга нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнтэй уялдуулж хувь хэмжээг тогтоож, тухай бүр шийдвэр гаргаагүй, бүтэн жилээр тогтмол олгож ирсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын удирдлагуудын ур чадварын нэмэгдлийг улирал тутам ажлын үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулан тухай бүр тогтоож олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 5 байгууллагын 2 байгууллагад дүгнэлт гаргаж /ЗДТГ/, Хужирт-Эрдэс баялаг УТҮГ, 3 байгууллагыг түүвэрт хамруулсан./ ИТХ, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр **282.2** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 8 албан шаардлага хүргүүлсэн.

- ЗДТГазарт-Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хотод сургалтад явах тээврийн зардалд 1080.0 мянган төгрөг, томилолтоор ирсэн хүмүүсийн хоолны зардалд 1084.0 мянган төгрөг, шагнал урамшуулал, хүүхдийн бэлгэд 1115.0 мянган төгрөг, нийт 3279.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад

-Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээших орлогын 4 удаагийн 43087.5 мянган төгрөгийн , зарлагын 5 удаагийн 203702.3 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

-Тайлант оны 11 сард 2982.0 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан, томилолтын зардал өмнөх оноос өссөн, батлагдсан төсвөөс хэтэрсэн, Бичиг хэргийн материалын үлдэгдэл 761.1 мянган төгрөгөөр өссөн, мөн бичиг хэргийн зардал өмнөх оноос өссөн, оны эцэст бичиг хэргийн материал их хэмжээтэй худалдан авсан.

-Тайлант онд 3900.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аж ахуй материалд бүртгэсэн

- Хужирт-Эрдэс баялаг УТҮГ-т- Бараа материалын 430.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй боловч эд хариуцагчийн тайлан гаргаагүй , бараа материалыг тоолоогүй, шатахууны тайлан гаргаагүй анхан шатны баримтууд дутуу, шаардах хуудсыг данс тус бүрээр салгаж тайлагнаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй

-Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулаагүй.Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

- ИТХ-д- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас журмын хашааны сахиулд гэрээ байгуулан 5560.1 мянган төгрөгийн цалин олгосон, 400.0 мянган төгрөгийг хүнсний материалд зарцуулсан, 46.0 мянган төгрөгийг хаягийн үнэнд зарцуулсан. /6,006.1/

- Мэдээлэл технологийн зардлаас 3900.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулж, хуваарилагдсан зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна. /3,900.0/

- Бараа үйлчилгээний бусад зардлаас 1000.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 1000.0 мянган төгрөгийг аймгийн ойн арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн. /2,000.0/

- Хөрөнгө зарцуулах 3399.0 мянган төгрөгийн 13 шийдвэрээс 2449.0 мянган төгрөгийн 9 шийдвэрийг Шилэн дансны сайтад мэдээлээгүй байна.

- ОНХС-д- Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй, авлага барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

- Шатахуун зарцуулахдаа жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй зэрэг зөрчил илэрлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн	Албан	Зөвлөмж	Хариуцлага	Хууль,

Хужирт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	акт		шаардлага		тооцуулах албан шаардлага		хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хужирт ТТЗ	1	0					1	0
Дүн								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 17-НИЙ ӨДӨР